



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС ХХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/70/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Эрдэнэзул
Утас: 261740 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	10
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
5.1 Шилэн дансны мэдээлэл	15
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
8. Аудитын илрүүлэлт	16
8.1 Залруулсан алдаа.....	16
8.2 Төлбөрийн акт.....	17
8.3 Албан шаардлага.....	17
8.4 Зөвлөмж	19
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/617

танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын тайлан

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 11,434.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, Компанийн тухай хууль, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн дүрэм"-ийн 3.5.4, 7.3.4, 7.3.5 дахь заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон зүйл

Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль, хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Эрдэнэс Монгол ХХК-ийн гаргасан Эрдэнэс-2, Эрдэнэс-3 бондын 215,494.7 сая төгрөгийн өглөгийг барагдуулсан, төлбөрийн 69.7 хувийг хүдэр, баяжмал борлуулахаар урьдчилж орсон орлогоос, 16.0 хувийг хуримтлагдсан ашгаас, 14.3 хувийг 2021 оны борлуулалтын орлогоос, тус тус барагдуулсан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг

аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Тайлант оны нийт орлогыг 216,157.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 74,788.0 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 141,369.9 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 116,456.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 53,479.5 сая төгрөгийн зардал гаргаж, 62,977.0 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Орлогын гүйцэтгэл 99,701.4 сая төгрөг буюу 46.1 хувиар буурсан нь Ковид-19 цар тахлын улмаас улсын хил хааж, борлуулалт зогссонтой холбоотой байна.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын 2021 оны бизнес төлөвлөгөөнд үйл ажиллагааны 6 чиглэлийн хүрээнд 25 зорилт дэвшүүлэн, хэрэгжилтийг тайлагнасан бөгөөд дүгнэх хугацаа болоогүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгөн хөрөнгө	35,371,777,532.52	777,988,520.87
1.1.2	Дансны авлага	627,550,208.41	2,570,613,019.65
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	42,800.00	1,056,142,311.89
1.1.4	Бусад авлага	116,384,925.33	128,350,223.23
1.1.6	Бараа материал	21,821,878,269.66	46,353,515,600.09
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	18,153,313,208.34	16,829,272,476.93
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	76,090,946,944.26	67,715,882,152.66
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	19,967,535,758.32	30,631,091,651.54
1.2.2	Биет бус хөрөнгө	7,344,338,453.10	6,216,173,079.34
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	6,935,081,113.95	18,923,208,223.79
1.1.6	Хойшлогдсон бондын хөрөнгө	1,146,077,542,881.00	972,354,274,733.44
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,180,324,498,206.37	1,028,124,747,688.11
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,256,415,445,150.63	1,095,840,629,840.77
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	214,132,196,483.62	7,749,697,331.97
2.1.1.3	Татварын өр	20,814,181,150.74	50,835,467,415.07
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	6,004,575,806.81	150,313,087,304.38
2.1.1.1	Бусад богино хугацаат өр төлбөр	636,479,937.71	280,749,160.31
2.1.1.1	Богино хугацаат өр төлбөрийн дүн	241,587,433,378.88	209,179,001,211.73
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.2	Урт хугацаат нөөц (өр төлбөр)	2,414,595,900.00	2,414,595,900.00
2.1.2.4	Бондын санхүүжилтийн өглөг	933,607,767,147.78	780,584,111,285.44
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	936,022,363,047.78	782,998,707,185.44
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,177,609,796,426.66	992,177,708,397.17
2.3	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.3.1	Өмч: а) төрийн	1,000,000.00	1,000,000.00
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	28,286,787,779.86	28,317,387,779.86
2.3.9	Хуримтлагдсан ашиг, алдагдал	50,517,860,944.11	75,344,533,663.74
2.3.11	Эздийн өмчийн дүн	78,805,648,723.97	103,662,921,443.60
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,256,415,445,150.63	1,095,840,629,840.77

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
А	Б	1	2
1	Борлуулалтын орлого (цэвэр)	99,765,723,035.74	112,787,915,721.74
2	Борлуулалтын өртөг	24,780,581,703.12	31,084,794,411.24
3	Нийт ашиг (алдагдал)	74,985,141,332.62	81,703,121,310.50
4	Түрээсийн орлого	17,056,609.07	1,316,994,551.32
5	Хүүгийн орлого	369,159,308.98	1,718,156,863.68
8	Бусад орлого	159,611,643.88	218,563,729.80
9	Борлуулалт, маркетингийн зардал	417,924,954.57	17,030,994,4 24.55
10	Ерөнхий ба удирдлагын зардал	8,688,801,288.51	4,950,291,5 56.93
11	Санхүүгийн зардал	127,022,326.93	0.00
12	Бусад зардал	78,007,123.00	413,443,867.74
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	540,816,666.77	414,883,366.87
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	66,760,029,868.31	62,976,989,972.95
19	Орлогын татварын зардал	16,178,876,373.86	14,528,687,567.33
20	Татварын дараах ашиг (алдагдал)	50,581,153,494.45	48,448,302,405.62
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	50,581,153,494.45	48,448,302,405.62

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	/төгрөгөөр/		
			Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000,0 00.00		-63,292,550.34	-62,292,550.34
2	Залруулсан үлдэгдэл	1,000,000.00		-63,292,550.34	-62,292,550.34
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			50,581,153,494.45	50,581,153,494.45
4	Өмчид гарсан өөрчлөлт		28,286,787,779.86		28,286,787,779.86
5	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000,000.00	28,286,787,779.86	50,517,860,944.11	78,805,648,723.97
6	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-23,621,629,686.00	-23,621,629,686.00
7	Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	28,286,787,779.86	50,517,860,944.11	78,805,648,7 23.97
8	Тайлангийн үеийн цэвэр ашиг	0.00	0.00	48,448,302,405.63	48,448,302,405.63
9	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	30,600,000.00	0.00	30,600,000.00
10	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000,000.00	28,317,387,779.86	75,344,533,663.74	103,662,921,4 43.60

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
А	Б	1	2
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	103,227,991,396.60	252,784,098,048.66
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	102,840,112,705.01	250,725,221,389.98
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	19,912,497.60	24,442,318.54
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	50,000.00	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	367,916,193.99	2,034,434,340.14
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	62,604,608,964.26	57,960,761,497.97
1.2.1	Ажиллагчдад олгосон мөнгө	2,620,443,172.51	5,281,476,188.72
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	780,392,817.95	1,148,961,148.82
1.2.3	Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө	1,307,295,461.01	41,712,475,435.10
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	3,817,220.00	2,742,736,670.90
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	26,479,487.00	4,250,874,901.30
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	25,689,394.87	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	544,187,094.62	1,272,947,364.26
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	370,656.00	103,399,126.28
1.2.9	Бусад мөнгөн зарлага	57,295,933,660.30	1,447,890,662.59
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	40,623,382,432.34	194,737,044,577.94
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	57,719.85	1,718,156,863.68
2.1.5	Бусдад олгосон зээл, урьдчилгааны буцаан төлөлт	57,719.85	-
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	-	1,718,156,863.68
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,194,528,767.19	231,020,674,626.02
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,041,617,192.85	14,963,154,440.52
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	152,911,574.34	62,810,737.50
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	215,494,709,448.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	500,000,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(5,194,471,047.34)	(229,216,225,789.59)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,218,260,785.60	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	560,949,327.00	-
3.1.4	Бусад орлого	657,311,458.60	
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,335,569,163.49	114,607,800.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	1,029,438,077.00	-
3.2.5	Бусад зарлага	306,131,086.49	114,607,800.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(117,308,377.89)	(114,607,800.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	35,311,603,007.11	(34,593,789,011.65)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	60,174,525.41	35,371,777,532.52
6	Мөнгөн, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	35,371,777,532.52	777,988,520.87

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I. ОРЛОГЫН ҮЗҮҮЛЭЛТ						
1.1	Үндсэн борлуулалтын орлого	97,177,971,800.00	214,427,400,000.00	107,287,991,600.51	(107,139,408,399.49)	50.0
1.1.1	Исэлдсэн хүдрийн орлого	56,335,405,900.00	81,325,200,000.00	38,216,636,529.79	(43,108,563,470.21)	47.0
1.1.2	Баяжмалын орлого	40,753,441,500.00	133,102,200,000.00	69,071,355,070.72	(64,030,844,929.28)	51.9
1.1.3	Металлын орлого	89,124,400.00				
1.2	Бусад орлого	3,133,528,800.00	1,730,500,000.00	8,753,639,266.03	7,023,139,266.03	505.8
1.2.1	Хүүгийн орлого		1,730,500,000.00	1,718,156,863.68	(12,343,136.32)	99.3
	Бусад орлого	3,133,528,800.00		7,035,482,402.35	7,035,482,402.35	
1.3	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз	540,867,100.00		414,883,366.87	414,883,366.87	
НИЙТ ОРЛОГО		100,852,367,700.00	216,157,900,000.00	116,456,514,233.41	(99,701,385,766.59)	53.9
II. ЗАРДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ						
2.1	Бүтээгдэхүүний өртөг	24,780,581,700.00	52,202,750,000.00	31,084,794,411.24	(21,117,955,588.76)	59.5
2.1.1	Хүдрийн өртөг	11,537,676,600.00	22,944,170,000.00	6,815,186,119.76	(16,128,983,880.24)	29.7
2.1.2	Баяжмалын өртөг	10,718,315,900.00	28,758,580,000.00	19,080,783,831.41	(9,677,796,168.59)	66.3
2.1.3	Металлын өртөг	25,887,700.00				
2.1.4	Эрсдэлийн зардал		500,000,000.00		(500,000,000.00)	-
	Бусад барааны өртөг	2,498,701,500.00		5,188,824,460.07	5,188,824,460.07	
2.5	Ерөнхий ба борлуулалт удирдлагын зардал	9,311,743,800.00	22,585,300,000.00	22,394,729,849.22	(190,570,150.78)	99.2
III. АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ						
4.1	Татвар төлөхийн өмнөх ашиг	66,760,042,200.00	141,369,850,000.00	62,976,989,972.95	(78,392,860,027.05)	44.5
	ААНОАТ	16,178,879,500.00	34,442,460,000.00	14,528,687,567.33	(19,913,772,432.67)	42.2
4.1	Татварын дараах цэвэр ашиг	50,581,162,700.00	106,927,390,000.00	48,448,302,405.62	(58,479,087,594.38)	45.3

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад өгсөн санхүүгийн тайлангийн тодруулгыг иж бүрэн, үнэн зөв тайлагнах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 22-оос 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хооронд Аудитын хоёр дугаар газрын ахлах аудитор Б.Эрдэнэзул гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр 01/54 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

ТУЗ-ийн 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 25 дугаар тогтоолоор шинэчилсэн компанийн зохион байгуулалтаар дотоод аудитын нэгж нь Гүйцэтгэх захирлын эрхлэх асуудлын хүрээнд шууд хамаарах нэгж бөгөөд компани стратеги төлөвлөгөөнийхөө дагуу санхүүгийн зорилгодоо хүрэхэд нь эрсдэлийн удирдлага, хяналт, засаглалын үйл ажиллагаанд нь баталгаажуулалт хийж хяналтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж гаргаж, хэрэгжилтийг хангуулах зорилготойгоор батлагдсан.

Тайлант онд 8 дугаар сараас эхлэн гүйцэтгэх захирлаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу 6 төрлийн ажлыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Эрдэнэс Силвер Ресурс ХХК нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зарлагын дүн 33,005.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 330.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн үзүүлэлтээр шинэчлэн 538.9 сая төгрөгөөр тогтоох шаардлагатай гэж үзсэн бөгөөд материаллаг байдлын суурь болон хувь хэмжээнд өөрчлөлт оруулаагүй болно.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн эрхэм зорилго нь байгалийн баялгийг удирдаж, үнэ цэнэ, үр өгөөжийг бий болгоход оршино.

Компанийн дүрэмд үйл ажиллагааны дараах 4 чиглэлийг тодорхойлжээ. Үүнд:

- Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх,
- Ашигт малтмал эрэх, хайх,
- Ашигт малтмал олборлох, ашиглах,
- Гэрээгээр өрөмдлөг хийх.

Компанийн үүсгэн байгуулагч, төрийн мэдлийн хувьцааг эзэмшигч нь “Эрдэнэс Монгол” ХХК /толгой компани гэх/ байна.

Тайлант онд бүтээгдэхүүний баяжигдах чанарын технологийн горимын туршилт судалгааг сайжруулж, борлуулалтын зорилтот үзүүлэлтүүдийг сайжруулан, агуулгын хувьд хэлбэлзэл багатай баяжмал үйлдвэрлэж, ашигт ажиллагааг сайжруулсан.

Өмнөх оны 5-р сараас 12-р сарыг дуусах хугацаанд мөнгөний металл авалт 73.3 хувь байсан бол, 2021 эхний хагас жилийн байдлаар 85.6 хувь, сүүлийн хагас жилд 88.1 хувь болж өссөн байна. Үйлдвэрлэсэн баяжмал дахь мөнгөний агуулга өмнөх оны 5-р сараас 12 сард 16,072 гр/тн -25,112 гр/тн байсан бол 2021 оны эхний хагас жилд 15,850 гр/тн-23,156 гр/тн, сүүлийн хагас жилийн байдлаар үйлдвэрлэсэн баяжмал дахь мөнгөний агуулгын хэлбэлзэл тогтворжиж 15,295 гр/тн-19,052 гр/тн болсон.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

ЗГ-ын 2014 оны 133 дугаар тогтоолоор Эрдэнэс Монгол ХХК-д охин болон хараат компани үүсгэн байгуулах¹ эрх олгосны дагуу ТУЗ-ийн 2019 оны 5 дугаар сарын 10 өдрийн 15 дугаар тогтоолоор Эрдэнэс силвер ресурс ХХК-ийг үүсгэн байгуулжээ.

¹ “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний охин компанийн үйл ажиллагааг дэмжих, уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ордын дэд бүтцийг хөгжүүлэх, ашиглах ажлын хүрээнд “Эрдэнэс Монгол” ХХК-ийг өөрөө эсхүл охин болон хараат компаниараа дамжуулан бусад аж ахуйн нэгжүүдийн хувьцааг эзэмших, хөрөнгө оруулах замаар охин болон хараат компанийг үүсгэн байгуулах, оруулсан хувь

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах...” гэсэн заалттай нийцэж байна.

Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг МУЗГ-ын 2016 оны 104 дүгээр тогтоолоор баталсан Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйл²-д заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлаас, гүйцэтгэх захирлыг мөн дүрмийн 9 дүгээр зүйл³-д заасны дагуу ТУЗ-өөс томилсон байна.

ТУЗ нь төрийн байгууллагаас 2, хөндлөнгийн хараат бус 3, компанийн гүйцэтгэх захирал, толгой компаниас 3, нийт 9 гишүүнээс бүрдэж байна.

ТУЗ-ийн 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 26 дугаар тогтоолоор шинээр томилогдсон гүйцэтгэх захирлыг ТУЗ-ийн сул гишүүний оронд түр томилсон байна.

ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоож, шийдвэр гаргаагүй байхад сард 0.8-аас 2.0 сая төгрөгийн цалин хөлс бодож олгосон байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13-т "компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох", Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Компанийн зохион байгуулалтын бүтцийг ТУЗ-ын 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 25 дугаар тогтоолоор шинэчлэн, орон тоог 85-аар бууруулсан нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3⁴-т заасантай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан хувь хэмжээнд 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт,
- Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

хөрөнгөө татан авах асуудлыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр гүйцэтгэх захирал шийдвэрлэж байхыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ч.Сайнбилэг), гүйцэтгэх захирал О.Сайнбуян нарт үүрэг болгосугай.

²8.2. Төлөөлөн удирдах зөвлөл 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг хувьцаа эзэмшигчийн хурал томилно.

³9.1. Компанийн гүйцэтгэх удирдлагын бүтцийг Төлөөлөн удирдах зөвлөл батлах бөгөөд гүйцэтгэх удирдлагын багийн гишүүнийг томилж, чөлөөлнө.

⁴Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	35,371,777.5	777,988.5	-34,593,789.0
Авлага	743,977.9	3,755,105.6	3,011,127.6
Бараа материал	21,821,878.3	46,353,515.6	24,531,637.3
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	18,153,313.2	16,829,272.5	-1,324,040.7
Үндсэн хөрөнгө	19,967,535.8	30,631,091.7	10,663,555.9
Биет бус хөрөнгө	7,344,338.5	6,216,173.1	-1,128,165.4
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	6,935,081.1	18,923,208.2	11,988,127.1
Хойшлогдсон бондын хөрөнгө	1,146,077,542.9	972,354,274.7	-173,723,268.1
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,256,415,445.2	1,095,840,629.8	-160,574,815.3
Дансны өглөг	214,132,196.5	7,749,697.3	-206,382,499.2
Татварын өр	20,814,181.2	50,835,467.4	30,021,286.3
Урьдчилж орсон орлого	6,004,575.8	150,313,087.3	144,308,511.5
Бусад богино хугацаат өр төлбөр	636,479.9	280,749.2	-355,730.8
Урт хугацаат нөөц (өр төлбөр)	2,414,595.9	2,414,595.9	0.0
Бусад урт хугацаат өр төлбөр	933,607,767.1	780,584,111.3	-153,023,655.9
Өмч: а) төрийн	1,000.0	1,000.0	0.0
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	28,286,787.8	28,317,387.8	30,600.0
Хуримтлагдсан ашиг, алдагдал	50,517,860.9	75,344,533.7	24,826,672.7
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,256,415,445.2	1,095,840,629.8	-160,574,815.3

Бэлэн мөнгөний үлдэгдэлд 1.6 сая төгрөгийн, Худалдаа хөгжлийн банкн дахь 4 харилцах дансанд 776.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Өмнөх оноос 34,593.8 сая төгрөгөөр буурсан нь Худалдаа хөгжлийн банкн дахь хадгаламжийн дансыг хааж, бондын төлбөр төлсөнтэй холбоотой байна.

Авлага 3,755.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас харилцагч байгууллагуудтай үүссэн дансны авлага 2,570.6 сая, НӨАТ-ын авлага 1,056.1 сая, барьцаа төлбөрийн авлага 121.3 сая, ажиллагсадтай холбогдсон авлага 7.1 сая төгрөг байна.

Авлага өмнөх оноос 3,011.1 сая төгрөгөөр өссөн нь бараа, ажил, үйлчилгээний болон НӨАТ-ын авлагын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Харилцагч байгууллагуудтай авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан бөгөөд Смарт Ложик ХХК-аас авах 7.8 сая, ажлаас гарсан 1 иргэнээс авах 2.2 сая төгрөгийн, Хотулун бэхи групп ХХК-аас авах 2.5 сая, Энержи плас инженеринг ХХК-аас авах 99.0 сая төгрөгийн нийт 111.5 сая төгрөгийн авлага маргаантай, хууль хяналтын байгууллагад хандсан байна.

Урьдчилж төлсөн төлбөр дансанд дараах 13 ажлын 16,826.3 сая төгрөг бүртгэлтэй байна. Тухайлбал:

- Баяжуулах үйлдвэрийн 4.9 сая ам.долларын тоног төхөөрөмжийг “Zenith mining and construction machinery salesco.ltd”-тай байгуулсан гэрээний үндсэн дээр худалдан авч байгаа бөгөөд баяжуулах үйлдвэр ашиглалтад бүрэн ороогүй тул суурилуулж, хүлээн авахаар хүлээгдэж, гэрээ дүгнэгдээгүй 12,730.4 сая төгрөг;
- Гантөмөр констракшн ХХК-аар гүйцэтгүүлж байгаа салхит уурхайн шинэ баяжуулах үйлдвэр, тунгаах цех, усан сан, агуулахын барилгын суурь, төмөр карказ, хана дээврийн барилга угсралтын ажлын урьдчилгаа төлбөр 2,158.0 сая төгрөг;
- Монголиан конкрете слийперс ХХК-тай байгуулсан гэрээний дагуу хүдэр буталж, ачилтад бэлтгэх ажлын урьдчилгаа төлбөр 709.0 сая төгрөг;
- Ажлын даалгавар өөрчлөгдсөн, нэмэлт ажил хийх болсон зэрэг шалтгаанаас 3 компанитай байгуулсан 877.8 сая төгрөгийн ажлын гэрээ дүгнээгүй;

- Монголын үндэсний олон нийтийн радио телевизтэй байгуулсан гэрээний дагуу урьдчилан шилжүүлсэн төлбөрөөс үлдсэн 76.1 сая төгрөгийн ажлыг цуцлах санал хүргүүлэн, шийдвэрлэх арга хэмжээ авч байна;
- Салхит уурхайн шинэ, хуучин үйлдвэр болон дээд кэмийг халаах уурын зуух, гадна дулааны шугам сүлжээ, дулаан механикийн барилга угсралтын ажил гүйцэтгүүлэхээр Энержи плас инженеринг ХХК-д төлсөн 99.0 сая төгрөгийн тооцоо маргаантай, хууль хяналтын байгууллагад хандсан.

Бараа материалын дансны үлдэгдэл 46,353.5 сая төгрөг болж 24,531.6 сая төгрөгөөр өссөн нь түүхий эд материал /овоолго/-ын олборлолт өмнөх оноос 7,883.9 сая төгрөгөөр, хилийн үйл ажиллагаа зогссонтой холбоотойгоор баяжмал, хүдэр гаалийн агуулахад хадгалагдаж, замд яваа бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл 17,192.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,663.5 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Дуусаагүй барилга байгууламж дансанд бүртгэлтэй Эрдэнэс ресорст-Их газрын чулуу, дэд станц 35кв, шинэ баяжуулах үйлдвэр, хатаах зуух зэрэг 4 барилга, байгууламж 12,440.0 сая төгрөгөөр;
- Барилга байгууламжийн дансанд гүний худаг, контейнер 40тн /тохижуулсан/, баяжуулах үйлдвэрийн барилга, газрын кабель 10 кв, усан сан, хатаах зуухны барилга, шугам хоолой /4-р худгийн 1-р усан сантай холбох 1200м/ зэрэг 7 төрлийн хөрөнгө 821.6 сая төгрөгөөр;
- Бусад тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, бусад хөрөнгө 1,825.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

Эрдэнэс Монгол ХХК-ийн харьяа охин компаниудад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасны дагуу тооллогын бүртгэлээр дутагдсан нийт 7 төрлийн 22.1 сая төгрөгийн хөрөнгийг хариуцагч нараар нөхөн төлүүлсэн байна.

Биет бус хөрөнгө 62.8 сая төгрөгөөр өссөн нь MV-021483 тоот ашиглалтын лицензийг шинээр бүртгэж, орлого авсантай холбоотой байна.

Хайгуул үнэлгээний дансны үлдэгдэл 18,923.2 сая болж 11,988.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд “Овоот хяр” хайгуулын талбайд батлагдан төсвийн дагуу гүйцэтгэсэн ажлын зардлыг хуримтлуулан бүртгэсэнтэй холбоотой байна.

Эрдэнэс Монгол ХХК, Эрдэнэс силвер ресурс ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр үүссэн Эрдэнэс-1, Эрдэнэс-2, Эрдэнэс-3 бонд 173,723.3 сая төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- МУЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан 1,146,088.5 сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий үнэт цаасны дүнг мөн оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 191 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулан 609.8 сая төгрөгөөр бууруулсан;
- Сивила Аудит ХХК-ийн дүгнэлтийг үндэслэн бондын 5 жилд тооцоолон хуримтлуулах 235,043.1 сая төгрөгийн хөнгөлөлтийг бөөнөөр бүртгэснийг залруулж, цаашид 2022-2025 онд 193,347.3 сая төгрөгийг жил бүр хуримтлуулан тооцохоор залруулга хийсэн;
- ТУЗ-ийн 2021 оны 19 дүгээр тогтоолоор Салхитын мөнгө-алтны ордын эдийн засгийн эргэлтэд оруулсан орлогоос компанийн 2020 оны санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг бууруулсан дүнгээр төрд ногдох өгөөжийн дүнг 23,724.5 сая төгрөгөөр баталж тохируулсан;
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс НДЕГ-тай тооцоо нийлж 186.9 сая, Хаан банкнаас Эрдэнэс Монгол ХХК-д хүсэлт хүргүүлэн 51.9 сая, Хадгаламж банктай үүссэн тооцооны 0.3 сая нийт 239.1 сая төгрөгийн Эрдэнэс 2, 3 бондын төлбөрийн буцаалт үүссэнийг бууруулан бүртгэсэн.

Богино хугацаат болон татварын, дансны өр төлбөрийн үлдэгдэл 58,865.9 сая төгрөг болж 176,716.9 сая төгрөгөөр буурсан нь Эрдэнэс Монгол ХХК /толгой компани/-д бонд-2, 3-ын 215,494.7 сая төгрөгийн төлбөрийг төлөхөөр өмнөх онд богино хугацаат өр төлбөр үүсгэснийг барагдуулсантай холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөрийн дансанд бүртгэлтэй бондын санхүүжилтийн өглөг 780,584.1 сая төгрөг болж, 153,023.6 буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- МУЗГ-ын 2020 оны 191 дүгээр тогтоолоор бондын нэрлэсэн үнэд өөрчлөлт орж, бонд 1-ийн дүнг 112.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн залруулсан;
- Бондын 2022-2025 онд тооцох 193,347.3 сая төгрөгийн бондын хөнгөлөлтийг тухайн жилүүдэд хуримтлуулан бүртгэх аудитын дүгнэлт⁵-ийг үндэслэн залруулга хийсэн.

Урт хугацаат нөөц дансанд уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн нөөцийг Солид Юнити аудит ХХК-ийн хараат бус аудиторын баталгаажуулсан дүгнэлтийг үндэслэн 2024 оны 12 сарын 31-ний өдрийн үнэ цэнээр 2,414.6 сая төгрөгөөр бүртгэсэн байна.

Мөнгөний хүдэр болон баяжмал худалдан авагчаас урьдчилан орж ирсэн 150,313.1 сая төгрөг орлого урьдчилж орсон орлого дансанд бүртгэсэн байна.

Эзэмшигчдийн өмчин бусад хэсэгт өмнөх компаниас шилжүүлэн авсан хөрөнгөөс 30.6 сая төгрөг дутуу бүртгэснийг нөхөн тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг⁶-ийн 4.10-ын бүлэгт зардлыг хөрөнгийн бууралт эсвэл өр төлбөрийн өсөлттэй холбоотой эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийн бууралт үүссэн, зардлын дүнг найдвартайгаар хэмжин тодорхойлж чадах үед, зардлыг холбогдох орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант үед орлоготой уялдаатайгаар хүлээн зөвшөөрч бүртгэхээр заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

Өмнөх онтой харьцуулахад нийт зардал 19,261.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь борлуулалт нэмэгдэж, борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн дүрэм"-ийн 7.3.5⁷-д заасны дагуу компани нь үйл ажиллагааны бизнес жилийн төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах үүрэгтэй.

Тус компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТУЗ-ийн 2020 оны 26 дугаар тогтоолоор анх баталж, нийт 295,187.7 сая төгрөгийн орлого олж, 67,655.8 сая төгрөгийн өртөг, зардал гаргаж, 227,532.0 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан байна. Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 46,699.6 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

⁵ Эрдэнэс Монгол ХХК-ийн Севиллиа Аудит ХХК-тай байгуулсан ЭМГЛ-35/УУГ-02/200221 тоот зөвлөх үйлчилгээний гэрээгээр гүйцэтгэсэн аудитын дүгнэлт.

⁶ Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 45 дугаар тогтоолоор баталсан нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг

⁷ Компанийн үйл ажиллагааны бизнес жилийн төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, ХЭХ-аар шийдвэрлүүлж, түүнийг шийдвэрлүүлж, түүний хэрэгжилтийг зохион байгуулах

ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 34 дугаар тогтоолоор төсвийн тодотгол хийж, орлогыг 79,029.8 сая төгрөгөөр бууруулж 216,157.9 сая төгрөгөөр, зардлыг 7,132.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 74,788.0 сая төгрөгөөр баталж, 106,927.4 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 116,456.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 53,479.5 сая төгрөгийн зардал гарган ашиг 62,977.0 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Тайлант онд 116,456.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөснөөс 99,701.4 сая төгрөгөөр буюу 46.1 хувиар тасарсан нь БНХАУ-ын хил хаагдаж, бүтээгдэхүүн борлуулалт зогссон, зарим бүтээгдэхүүн хүргэлтийн цэгт хүрээгүй замд яваа зэрэгтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 53,479.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 21,308.5 сая төгрөг буюу 28.4 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна.

Бэлэн бүтээгдэхүүний борлуулалт зогссонтой холбоотойгоор борлуулсан бүтээгдэхүүний өртөг 25,806.8 сая төгрөгөөр, борлуулалт, удирдлагын зардал 717.1 сая төгрөгөөр, тайлант үеийн ашиг 53,166.3 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

Хөрөнгө оруулалтын зардлын төсвийн анх 46,699.6 сая төгрөгөөр баталсаныг тодотголоор 31,466.3 сая төгрөг болгож 15,233.3 сая төгрөгийн хэмнэлт гаргасан.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 25 нэр төрлийн 31,466.3 сая төгрөгийн ажил хийж гүйцэтгэхээс өөрийн эх үүсвэрээс 27,607.8 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэс Силвер Ресурс ХХК нь тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим системд нийт 160 мэдээлэл байршуулахаас 30-ыг хугацаа хоцроон байршуулсан зөрчилтэй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг цаг хугацаанд нь мэдээлж байх албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн

холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

Ажилтнуудад эхний хагас жилд нэг сарын үндсэн цалингаар, жилийн эцэст сарын дундаж цалингаар тооцон нийт 615.8 сая төгрөгийн урамшуулал бодож олгосон нь МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-т "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, ... шагнал, урамшуулал олгохгүй байх, ..." гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 953.4 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1,118.4 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснөөс албан шаардлага 81.4 хувь, зөвлөмж 81.2 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	2	953.4	1	953.4	1	0.0	81.4
Зөвлөмж	2	1,118.4	1	908.6	1	209.8	81.2
Нийт дүн	4	2,071.8	2	1,862.0	2	209.8	81.3

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлагын хэрэгжилт 81.4 хувь, бараа материалын үлдэгдэлд хүдрийн 7 дугаар овоолго хасах үлдэгдэлтэй тайлагнагдаж байгаа бүртгэлийг нягтлан бодох бүртгэлд тусгах зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, гүйцэтгэх захирлын шийдвэрээр залруулга хийж бүртгэлд тусгасан бөгөөд 81.2 хувьтай байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй болон илүүдэл нөөц хөрөнгө бэлтгэсэн эсэхэд дүн шинжилгээ хийж, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлнэ.

Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн Салхитын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, үнэт цаас гаргах ажилтай холбоотой худалдан авалтуудыг холбогдох байгууллагаас тодруулан, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 заалтад хамааруулан шууд худалдан авалт хийсэн байна. Иймд дараагийн аудитаар Үндэсний аудитын газрын нууцтай танилцах эрх бүхий нэгжээр дүгнэлт гаргуулж, нууцын хамрах хүрээг тодорхой болгох шаардлагатай гэж шийдвэрлэв.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 26,516.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 14,540.2 сая төгрөгийн алдааг залруулж, 3.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11,973.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 11,973.1 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон 538.9 сая төгрөгийн ерөнхий материаллаг байдлын түвшнээс 11,434.2 сая төгрөгөөр их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 14,540.2 сая төгрөгийн дараах 2 алдааг залрууллаа. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланд 1,125.0 сая төгрөгийн бусад орлогыг борлуулалтын орлогоор тайлагнасан;
- мөн тайланд 13,415.1 сая төгрөгийн ажиллагсадтай холбогдон гарсан зардал, түүхий эд материал авах, бусад зардлын дансыг ангилал зөрүүлэн тайлагнасан.

8.2 Төлбөрийн акт

1. Гүйцэтгэх захиралтай байгуулсан хөлсөөр ажиллах гэрээнд тусгаагүй унаа хоолны хөнгөлөлтөд 3.6 сая төгрөгийн нэмэгдэл цалин хөлс бодож олгосон.

Гүйцэтгэх захиралтай байгуулсан хөлсөөр ажиллах гэрээний 6.1-т "Гүйцэтгэх захиралд сард 7,000,000.00 /долоон сая/ төгрөгийн цалин хөлс олгох ба компанийн үр дүн, ашиг орлогоос шалтгаалж, цалингийн хэмжээг гэрээний хугацаанд батлагдсан төсөвт нийцүүлэн өөрчлөн тогтоож болно", Компанийн тухай хуулийн 62.1.13-т "компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

8.3 Албан шаардлага

1. ТУЗ-ийн 9 гишүүнд олгох цалингийн хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоож, шийдвэр гаргаагүй байхад сард 0.8-аас 2.0 сая төгрөгөөр бодож нийт 143.7 сая төгрөгийн цалинг тооцож олгосон байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 62.1.13-т "компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.

2. Компанийн төсөвт туслан гүйцэтгэгч компаниудад хөрөнгө түрээслүүлэх, шатахуун, сэлбэг хэрэгслийн борлуулалт хийх ажлыг тусгаагүй, батлагдаагүй хөрөнгө оруулалтын ажлыг урьдчилан хийж гүйцэтгэсний дараа тодотгосон, зарим зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслээгүй хэт ерөнхий байдлаар төлөвлөн батлуулсан байна.

Тухайлбал:

- Туслан гүйцэтгэгч компаниудад ашиглалтын зардал, шатахуун, зарим тоног төхөөрөмжийг худалдах, тоног төхөөрөмж, кэмп түрээслүүлэх зэргээр нийт 7,035.5 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 5,188.8 сая төгрөгийн өртөг гарсныг жилийн төсөв, төлөвлөгөөнд тусгаагүй;
- Төлөвлөлтийг үндэслэлтэй, тооцоо судалгаатайгаар боловсруулаагүйгээс 8 төрлийн 3,860.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг хийж гүйцэтгэсний дараа, 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн ТУЗ-ийн 34 дугаар тогтоолоор тодотгон, нэмж батлуулсан;
- Борлуулсан бүтээгдэхүүний өртөг, хайгуулын үнэлгээний хөрөнгийн зардлыг бөөн дүнгээр батлуулсан.

Энэ нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн дүрэм"-ийн 3.5-д "Компани нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтлана: 3.5.4 тооцоо, судалгаанд суурилдаг байх", 7.3.4-т "хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулалт, ашиглалт, компанийн хөдөлмөрийн дотоод журамд хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх", 7.3.5-д "Компанийн үйл ажиллагааны бизнес жилийн төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, ХЭХ-аар шийдвэрлүүлж, түүнийг шийдвэрлүүлж, түүний хэрэгжилтийг зохион байгуулах", Гүйцэтгэх захирлын хөлсөөр ажиллах гэрээний 4.1-д "... тухайн жилийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг

хангах ажлыг удирдан зохион байгуулах, ..." гэж заасантай тус тус нийцээгүй, нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

3. Гүйцэтгэх захирлын 2020 оны А/50 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааны журам"-ын зарим заалт бусад хууль тогтоомжтой нийцээгүй, зарим харилцааг тодорхой зохицуулаагүй байгаа нь цаашид чанаргүй бараа, ажил, үйлчилгээ бэлтгэх, төрийн өмч үр ашиггүй зарцуулагдах, ашиглан шамшигдуулах зэрэг эрсдэлтэй байна.

Тухайлбал:

- Тус журмын 2.3, 2.4 дэх заалтад Гүйцэтгэх захирал төсөвт тусгаагүй худалдан авалтыг хийж болохоор зохицуулсан;
- Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар харьцуулалт хийж, үнэлэхдээ зөвхөн үнийн санал, техникийн үзүүлэлтийг авч үзэхээр зохицуулсан бөгөөд санхүүгийн болон ерөнхий чадавхи, туршлага зэргийг харгалзаж үзээгүй;
Тайлант онд 12 удаагийн 4,435.8 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн компанийн үйл ажиллагааны чиглэл тухайн ажлыг гүйцэтгэхэд тохироогүй, үүнээс хүдэр буталж, ачилтад бэлтгэх үндсэн ажлыг гүйцэтгэдэг туслан гүйцэтгэгч компаниуд нь уул уурхайн тоног төхөөрөмж худалдаа, зөвлөгөө өгөх, аялал жуулчлал, барилгын засвар үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах бүртгэлтэй;
Мөн Хүдэр буталж, ачилтад бэлтгэх 2,070.0 сая төгрөгийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ажлын туршлагыг харгалзаагүй, 2020 оны 6 сард үүсэн байгуулагдсан, хүнд үйлдвэрийн тоног төхөөрөмж, барилгын материалын худалдаа, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах компанитай гэрээ байгуулсан;
- Гэрээний гүйцэтгэлийг үнэлэх, бараа, ажил, үйлчилгээг хүлээн авах зохицуулалт тодорхой бус байна. Тухайлбал гүйцэтгэсэн бараа, ажил, үйлчилгээг хүлээн авах ажлын хэсэг томилдоггүй, зарим ажилд ашиглагч, нарийн мэргэжилтнүүд оролцоогүй, ажлын актыг ажлын даалгавар дахь үзүүлэлтийн дагуу хянаж хүлээж авч хэвшээгүй;
- Санхүүгийн чадавхыг үнэлээгүй, төлбөрийн баталгаа гаргаагүй байхад урьдчилгаа төлбөрийг хэт өндөр буюу 50-100 хувиар олгосон; Жилийн эцсийн байдлаар гэрээний хугацаа дууссан ч гүйцэтгэл гараагүй 1,782.7 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардал, мөн гэрээний дагуу үүссэн болон хугацаа дууссан 1,872.3 дансны авлагын үлдэгдэлтэй.

Энэ нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн дүрэм"-ийн 3.5.4, 7.3.4, 7.3.5, Гүйцэтгэх захирлын хөлсөөр ажиллах гэрээний 4.1-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

4. Жилийн зорилтот түвшин, төсвийн гүйцэтгэлээс нийт 12 нэр төрлийн зардлыг 211.6 сая, хөрөнгө оруулалтын тээврийн хэрэгсэл авах зардлыг 60.9 сая төгрөгөөр тус тус хэтрүүлж, 3 нэр төрлийн 85.6 сая төгрөгийн төлөвлөөгүй зардал гаргасан байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 83.1-д "Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна" гэж заасантай болон Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн дүрэм"-ийн 3.5.4, 7.3.4, 7.3.5, Гүйцэтгэх захирлын хөлсөөр ажиллах гэрээний 4.1 дэх заалттай тус тус нийцэхгүй байна. Тухайлбал:

- ТУЗ-ийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 170.5 сая, засварын болон хангамжийн материалын зардлыг 127.5 сая, бичиг хэрэг, шуудан холбооны зардлыг 45.0 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн;
- Банк санхүүгийн үйлчилгээний зардал, хог хаягдлын зардал, хурал уулзалтын зардлыг төсөвлөөгүй,
- Хөрөнгө оруулалтын зардлаас авто машин, тээврийн хэрэгсэл авах зардлыг 60.9 сая төгрөгөөр хэтрүүлсэн.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

5. Бараа материал /хүдрийн овоолго/ орлого авах, зарцуулахад гарсан биет хэмжээний зөрүү залруулах талаар НББ-ийн бодлогын баримт бичигт тусгаж мөрдөх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, 2021 оны жилийн эцэст овоолгын 209.8 сая төгрөгийн сөрөг үлдэгдэл байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10 “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэж заасантай нийцээгүй, бөгөөд өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн тодруулгатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн тодруулга хүснэгтүүдийг зааврын дагуу бэлтгэсэн ч холбогдох дансдын үлдэгдэл, тухайн жилд гарсан онцлог ажил гүйлгээ зэргийг тайлбарлан тодруулж, тэмдэглэл бичээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна: 8.1.5.санхүүгийн тайлангийн тодруулга”, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар-ын 6-р бүлгийн “Санхүүгийн тайлангийн тодруулга”, Хоёрдугаар хавсралтаар баталсан “санхүүгийн тайлангийн маягт”-тай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлангийн тодруулгыг иж бүрэн, үнэн зөв бэлтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар														
1	Эрдэнэс силвер ресурс ХХК	АХГ-2022/70/НА-СТА-ТӨА	ТУЗ-ийн 9 гишүүнд олгох цалингийн хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоож, шийдвэр гаргаагүй байхад сард 840.0-өөс 2,000.0 мянган төгрөгөөр бодож нийт 143,662.7 мянган төгрөгийн цалин бодож олгосон.	ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлсний хэмжээг байгууллагын үйл ажиллагааны хүрээ, санхүү эдийн засгийн байдлыг харгалзан ХЭХ-аас тогтоосны үндсэн дээр олгож байх.	1	143,662.7					1	143,662.7		
2	Эрдэнэс силвер ресурс ХХК	АХГ-2022/70/НА-СТА-ТӨА	Гүйцэтгэх захиралтай байгуулсан хөлсөөр ажиллах гэрээнд тусгаагүй унаа, хоолны хөнгөлөлтөд 3,645.0 мянган төгрөгийн нэмэгдэл цалин хөлс бодож олгосон.	Хөлсөөр ажиллах гэрээнд тусгаагүй нэмэгдлийг нөхөн төлүүлэх	1	3,645.0			1	3,645.0				
3	Эрдэнэс силвер ресурс ХХК	АХГ-2022/70/НА-СТА-ТӨА	Компанийн төсөвт туслан гүйцэтгэгч компаниудад хөрөнгө түрээслүүлэх, шатахуун, сэлбэг хэрэгслийн борлуулалт хийх ажлыг тусгаагүй, зарим зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслээгүй хэт ерөнхий байдлаар төлөвлөж, батлуулсан байна. Тухайлбал: 1. Туслан гүйцэтгэгч компаниудад ашиглалтын зардал, шатахуун, зарим тоног төхөөрөмжийг худалдах, тоног төхөөрөмж, кэмп түрээслүүлэх зэргээр нийт 7,035,482.4 мянган төгрөгийн борлуулалтын орлого олж, 5,188,824.5 мянган төгрөгийн өртөг гарсныг төсөвт тусгаагүй байна. 2. Төлөвлөлтийг үндэслэлтэй, тооцоо судалгаатайгаар боловсруулаагүйгээс 8 төрлийн 3,859,887.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг хийж гүйцэтгэсний дараа, ТУЗ-ийн 2021.12.23-ны өдрийн 34 дугаар тогтоолоор тодотгол хийлгэн, нэмж батлуулсан байна. 3. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг, хайгуулын үнэлгээний хөрөнгийн зардлыг бөөн дүнгээр батлуулсан байна.	Жилийн бизнес төлөвлөгөө, төсвийг бодит тооцоо судалгаанд үндэслэн хэлэлцүүлэн батлуулах, гаргасан шийдвэрийг чанд мөрдөж байх	1	7,035,482.4					1	7,035,482.4		

4	Эрдэнэс силвер ресурс ХХК	АХГ- 2022/70/НА -СТА-ТӨА	<p>Гүйцэтгэх захирлын 2020 оны А/50 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааны журам"-ын зарим заалт бусад хууль тогтоомжтой нийцээгүй, зарим харилцааг тодорхой зохицуулаагүй байгаа нь цаашид чанаргүй бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх, төрийн өмч үр ашиггүй зарцуулагдах зэрэг эрсдэлтэй байна. Тухайлбал:</p> <p>1. Тус журмын 2.3, 2.4 дэх заалтад Гүйцэтгэх захирал төсөвт тусгаагүй худалдан авалтыг хийж болохоор зохицуулсан.</p> <p>2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар харьцуулалт хийж, үнэлэхдээ санхүүгийн болон ерөнхий чадавхи, туршлага зэргийг харгалзаж үзээгүй байна. Тайлант онд 12 удаагийн 4,435,834.2 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн компанийн үйл ажиллагааны чиглэл тухайн ажлыг гүйцэтгэхэд тохироогүй байна.</p> <p>3. Гэрээний гүйцэтгэлийг үнэлэх, бараа, ажил, үйлчилгээг хүлээн авах зохицуулалт тодорхой бус байна. Гүйцэтгэсэн бараа, ажил, үйлчилгээг хүлээн авах ажлын хэсэг томилдоггүй, зарим ажилд ашиглагч, нарийн мэргэжилтнүүд оролцоогүй, ажлын актыг ажлын даалгавар дахь үзүүлэлтийн дагуу хянаж хүлээж авч хэвшээгүй байна.</p> <p>4. Санхүүгийн чадавхийг үнэлээгүй, төлбөрийн баталгаа гаргаагүй байхад урьдчилгаа төлбөрийг хэт өндөр буюу 50-100 хувиар олгож байна. Жилийн эцсийн байдлаар гэрээний хугацаа дууссан ч гүйцэтгэл гараагүй 1,782,713.4 мянган төгрөгийн урьдчилж төлсөн зардал, мөн гэрээний дагуу үүсгэсэн болон хугацаа дууссан 1,872,328.8 мянган төгрөгийн дансны авлагын үлдэгдэлтэй байна.</p>	Худалдан авах ажиллагааны гүйцэтгэгч сонгон шалгаруулах, гүйцэтгэлд хяналт тавьж, хэрэгжилтийг хангах явцыг тодорхой болгох	1	4,435,834.2					1	4,435,834.2		
5	Эрдэнэс силвер ресурс ХХК	АХГ- 2022/70/НА -СТА-ТӨА	ТУЗ-өөс баталсан төсөв, төлөвлөгөөг мөрдөөгүй 12 нэр төрлийн зардлыг нийт 211,629.8 мянган төгрөгөөр хэтрүүлж, 3 нэр төрлийн 85,565.1 мянган төгрөгийн төсөвлөөгүй зардал гаргасан байна.	ТУЗ-өөс баталсан жилийн төсөв, төлөвлөгөөг чанд мөрдөж ажиллах	1	358,095.0					1	358,095.0		
6	Эрдэнэс силвер ресурс ХХК	АХГ- 2022/70/НА -СТА-ТӨА	Санхүүгийн тайлангийн тодруулга хүснэгтүүдийг зааврын дагуу бэлтгэсэн ч холбогдох дансдын үлдэгдэл, тухайн жилд гарсан онцлог ажил гүйлгээ зэргийг тайлбарлан тодруулж, тэмдэглэл бичээгүй байна.	Санхүүгийн тайлангийн тодруулгыг иж бүрэн хийж байх	1	-							1	
7	Эрдэнэс силвер ресурс ХХК	АХГ- 2022/70/НА -СТА-ТӨА	Бараа материал /хүдрийн овоолго/ орлого авах, зарцуулахад гарсан биет хэмжээний зөрүү залруулах талаар НББ-ийн бодлогын баримт бичигт тусгаж мөрдөх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, 2021 оны бараа материалын үлдэгдэлд овоолго-7 данс 209,793.5 мянган төгрөгийн сөрөг үлдэгдэлтэй тайлагнасан байна.	Овоолгын бүртгэлийн онцлогийг НББ-д тусгаж, батлуулан мөрдөх	1	-					1			

8	Эрдэнэс силвер ресурс ХХК	АХГ- 2022/70/НА -СТА-ТӨА	Мөнгөн гүйлгээний тайланд орлогыг 1,125,018.5 мянган төгрөгөөр, бусад зардлыг 13,415,153.7 мянган төгрөгөөр данс зөрүүлж тайлагнасан.	Залруулга хийх	1	14,540,172.3	1	14,540,172.3						
ДҮН					8	26,516,891.6	1	14,540,172.3	1	3,645.0	5	11,973,074.3	1	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал														
1	Эрдэнэс силвер ресурс ХХК	АХГ- 2022/70/НА -СТА-ТӨА	Ажилтнуудад эхний хагас жилд нэг сарын үндсэн цалингаар, жилийн эцэст сарын дундаж цалингаар тооцон нийт 615,833.5 мянган төгрөгийн урамшуулал бодож олгосон.	Засгийн газрын аливаа шийдвэрийг мөрдөж байх, уг зөрчлийг давтан гаргахгүй байх	1	615,833.5						1	615,833.5	
2	Эрдэнэс силвер ресурс ХХК	АХГ- 2022/70/НА -СТА-ТӨА	Шилэн дансны нэгдсэн цахим системд нийт 160 мэдээлэл байршуулахаас 30-ыг хугацаа хоцроон байршуулсан байна.	Гаргасан зөрчлийг арилгах давтан гаргахгүй ажиллах	1	-						1		
ДҮН					2	615,833.5	0	-	0	-	2	615,833.5	1	-
НИЙТ ДҮН					10	27,132,725.1	1	14,540,172.3	1	3,645.0	7	12,588,907.8	1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

᠒᠐᠒᠒ оны ᠐᠒ дугаар сарын ᠒᠑ -

№ 134/᠒᠐16᠐᠐᠖᠑

Улаанбаатар хот

АХГ - ᠒᠐᠒᠒/᠑᠙/᠑᠕᠕ -᠑᠕᠕ -᠑᠐᠕
Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөлсөөр ажиллах гэрээнд тусгаагүй унаа, хоолны хөнгөлөлтөд 3,645,000.00 төгрөгийг бодож олгосон.

Энэ нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс Гүйцэтгэх захиралтай байгуулсан хөлсөөр ажиллах гэрээний 6.1 "Гүйцэтгэх захиралд сард 7,000,000.00 /долоон сая/ төгрөгийн цалин хөлс олгох ба компанийн үр дүн, ашиг орлогоос шалтгаалж, цалингийн хэмжээг гэрээний хугацаанд батлагдсан төсөвт нийцүүлэн өөрчлөн тогтоож болно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-д заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Үндэслэлгүй олгосон цалингийн нэмэгдэл 3,645,000.00 /гурван сая зургаан зуун дөчин таван мянга/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Баярмөнх, ерөнхий нягтлан бодогч Д.Батжаргал нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Б.ЭРДЭНЭЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тоируу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-261230

Z:\aki\2022\0315 Auditin 2 Газар-69.Docx

0001090315



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 590/АО 160063

Улаанбаатар хот

АХГ - 2022/70/НА - СТН - 70А

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим системд нийт 160 мэдээлэл байршуулахаас 30 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Баярмөнх, ерөнхий нягтлан бодогч Д.Батжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

ЦНАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Б.ЭРДЭНЭЗУЛ

0001081570



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 05

№ 591/Ао 160063

Улаанбаатар хот

АХГ-2022/70 НА-СГА-ТОН

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын тайланд хүдрийн 7 дугаар овоолгын дансны үлдэгдлийг сөрөг утгатай илэрхийлснийг өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусган мөрдөх, залруулга хийх зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна. Тайлант онд тус овоолгын дансанд 209,793,502.04 төгрөгийн сөрөг утгатай үлдэгдэл тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10 "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий талбар хүргүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хүдрийн овоолгын бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусган залруулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Баярмөнх, ерөнхий нягтлан бодогч Д.Батжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Б.ЭРДЭНЭЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-281.Docx

0001081568



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

᠒᠐᠒᠒ оны ᠒3 дугаар сарын 15

№ 59᠒/А᠐16᠐᠐᠖8

Улаанбаатар хот

АХГ - ᠒᠐᠒᠒ /᠙᠐/НА -᠑᠑А - ᠒᠐᠒᠒

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн төсөвт туслан гүйцэтгэгч компаниудад хөрөнгө түрээслүүлэх, шатахуун, сэлбэг хэрэгслийн борлуулалт хийх үйл ажиллагааны чиглэлийг тусгаагүй, зарим зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслээгүй хэт ерөнхий байдлаар төлөвлөж, батлуулсан байна. Тухайлбал, туслан гүйцэтгэгч компаниудад ашиглалтын зардал, шатахуун, зарим тоног төхөөрөмжийг худалдах, тоног төхөөрөмж, кэмп түрээслүүлэх зэргээр нийт 7,035,482,402.35 төгрөгийн борлуулалтын орлого олж 5,188,824,460.07 төгрөгийн өртөг гарсныг төсөвт тусгаагүй, Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлээгүй байна.

Энэ нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн дүрэм"-ийн 7.3.4 "хувьль тогтоомжийн хэрэгжилт, санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулалт, ашиглалт, компанийн хөдөлмөрийн дотоод журамд хяналт тавих, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх", 7.3.5 "Компанийн үйл ажиллагааны бизнес жилийн төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлж, түүний хэрэгжилтийг зохион байгуулах", Гүйцэтгэх захирлын хөлсөөр ажиллах гэрээний 4 дүгээр зүйлийн 4.6 "Гүйцэтгэх захирал дараах асуудлуудыг Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрлийг авсны үндсэн дээр шийдвэрлэнэ: Эрхлэх бизнесийн үндсэн төрөл, чиглэлээс өөр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Жилийн үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөнд тусгаагүй үйл ажиллагаа явуулсан, төсвийг бодит тооцоо судалгаанд үндэслээгүй зэрэг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Баярмөнх, ерөнхий нягтлан бодогч Д.Батжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.ЭНХДАЛАЙ

АХЛАХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭЗУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

᠒᠐᠒᠒ оны ᠒2 дугаар сарын ᠒᠕

№ 593/᠕᠐ 16᠐᠐6᠘

Улаанбаатар хот

АХГ - ᠒᠐᠒᠒ / ᠑᠐ / НА - СТА - ДА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:




Гүйцэтгэх захирлын 2020 оны А/50 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааны журам"-д гүйцэтгэх захирал төсөвт батлагдаагүй хөрөнгө оруулалтыг хийж болохоор тусгасан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үзүүлэлт хангалтгүй, урьдчилгаа төлбөр олгох шалгуур тодорхойгүй, гүйцэтгэлийг хянаж хүлээн авах, ашиглалтад оруулах хяналт тавих зохицуулалт хангалтгүй байна. Тухайлбал тайлант онд тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх үйл ажиллагааны чиглэл таарахгүй 12 гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 4,435,834,160.90 төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгүүлсэн.

Энэ нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн дүрэм"-ийн 7.3.5 "Компанийн үйл ажиллагааны бизнес жилийн төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлж, түүний хэрэгжилтийг зохион байгуулах", Гүйцэтгэх захирлын хөлсөөр ажиллах гэрээний 4.1 "Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэм, Үндэсний аюулгүй байдал, Засгийн газар, Хувьцаа эзэмшигчээс өгсөн шийдвэрийн дагуу компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, техник технологийг шинэчлэх, тухайн жилийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг удирдан зохион байгуулах, компанийг санхүү, эдийн засгийн үр өгөөжтэй, ашигтай байхаар удирдах ажиллагсдын нийгмийн асуудлыг оновчтой шийдвэрлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны журмыг бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулан мөрдөж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Баярмөнх, ерөнхий нягтлан бодогч Д.Батжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР		Д.ЭНХДАЛАЙ
АХЛАХ АУДИТОР		Б.ЭРДЭНЭЗУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

᠒᠐᠒᠒ оны ᠒᠘ дугаар сарын ᠒᠘

№ ᠑᠑4/᠕᠐ 16᠐᠐᠖᠑

Улаанбаатар хот

АХГ - ᠒᠐᠒᠒ 1᠙᠐/1᠕᠕ - ᠑᠒᠕ - ᠑᠒᠕

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан төсвийг мөрдөөгүй, жилийн эцсийн байдлаар 12 нэр төрлийн зардлыг нийт 211,629,796.05 төгрөгөөр хэтрүүлж, 3 нэр төрлийн 85,565,177.29 төгрөгийн төсөвт батлагдаагүй зардал гаргасан;

Хөрөнгө оруулалтын зардлаас тээврийн хэрэгсэл худалдан авах зардлыг 60,900,000.0 төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 83.1 "Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна", Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн дүрэм"-ийн 7.3.5 "Компанийн үйл ажиллагааны бизнес жилийн төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлж, түүний хэрэгжилтийг зохион байгуулах", Гүйцэтгэх захирлын хөлсөөр ажиллах гэрээний 4.1 "... тухайн жилийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг удирдан зохион байгуулах, ..." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан жилийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг мөрдөөгүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Баярмөнх, ерөнхий нягтлан бодогч Д.Батжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.ЭНХДАЛАЙ

АХЛАХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-2᠖4230

\\10.10.10.20\Richig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-278.Docx

0001021562



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

᠒᠐᠒᠒ оны ᠒3 дугаар сарын ᠒᠕

№ 595/᠕᠐.16᠐᠐.᠖3

Улаанбаатар хот

АХГ - ᠒᠐᠒᠒/᠕᠐/НА - ЕН - ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 9 гишүүнд олгох цалингийн хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоож, шийдвэр гаргаагүй байхад сард 840 000.00-2,000,000.00 төгрөгөөр тооцож нийт 143,662,729.00 төгрөгийн цалин олгосон байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 "Дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ: 62.1.13. компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлсний хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Баярмөнх, ерөнхий нягтлан бодогч Д.Батжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

АХЛАХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭЗУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 15

№ 596/20 160068

Улаанбаатар хот

ХХГ - 0200X / 170 / 11А - 978 - 105
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилтнуудад эхний хагас жилд нэг сарын үндсэн цалингаар, жилийн эцэст сарын дундаж цалингаар тооцон нийт 615,833,523.00 төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 "... шагнал, урамшуулал олгохгүй байх, ..." Гүйцэтгэх захирлын хөлсөөр ажиллах гэрээний 4.1 "Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэм, Үндэсний аюулгүй байдал, Засгийн газар, Хувьцаа эзэмшигчээс өгсөн шийдвэрийн дагуу компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, техник технологийг шинэчлэх, тухайн жилийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг удирдан зохион байгуулах, компанийг санхүү, эдийн засгийн үр өгөөжтэй, ашигтай байхаар удирдах, ажиллагсдын нийгмийн асуудлыг оновчтой шийдвэрлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газар, холбогдох дээд шатны төрийн байгууллагуудаас гаргасан тушаал, шийдвэрийг мөрдөж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Баярмөнх, ерөнхий нягтлан бодогч Д.Батжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Б.ЭРДЭНЭЗУЛ